



Tel: +976 77404041
Fax: +976 77451150
www.bdo.mn

Level 10, AB Center Building,
University Street,
11 th Khorooolol, khorooolol-6,
Sukhbaatar District-14193,
Ulaanbaatar, Mongolia

Утас: +976 77404041
Факс: +976 77451150
www.bdo.mn

АБ Цэнтр, 10 давхар
СБД-6, 11-р хороолол
Улаанбаатар Монгол улс
14193

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“БиДиСек” ХК-ийн хувь нийлүүлэгчдэд

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн талаарх

Бид “БиДиСек” ХК-ийн 6-55 дугаар хуудсанд тусгагдсан 2014 оны 12 сарын 31-ний өдрийн Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан, энэ өдрөөр тасалбар болсон жилийн Нэгтгэсэн Ашиг, Алдагдал болон Бусад Дэлгэрэнгүй Орлогын тайлан, Нэгтгэсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан, Нэгтгэсэн Мөнгөн гүйлгээний тайлан, Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд ба бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн нэгтгэсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Нэгтгэсэн санхүүгийн тайланд удирдлагын хүлээх үүрэг хариуцлага

Удирдлага нь эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (“СТОУС”)-ын дагуу бэлтгэж, шударгаар иж бүрэн толилуулах үүрэгтэй. Үүнд: санхүүгийн тайлангуудыг алдаа юм уу заль мэхнээс үүдэлтэй материаллаг буруу илэрхийллээс ангид бэлтгэж, шударгаар толилуулахуйц дотоод хяналтыг тогтоож, ажиллуулан, хэвийн түвшинд сахих, тохиромжтой нягтлан бодох бүртгэлийн бодлогыг сонгож, хэрэглэх, нөхцөл байдалд тохирсон нягтлан бодох бүртгэлийн тооцоолол хийх үүрэг хариуцлага багтдаг.

Аудиторын хүлээх хариуцлага

Бид гүйцэтгэсэн аудитдаа тулгуурлан эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлангуудад дүгнэлт гаргах үүрэгтэй. Бид аудитаа Нягтлан Бодогчдын Олон Улсын Холбооноос батлан гаргасан Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэлээ. Эдгээр стандарт нь нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь материаллаг зөрчилгүй илэрхийлэгдсэн эсэх талаарх зохих нотолгоог олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, ёс зүйн шаардлагуудыг баримтлан гүйцэтгэхийг биднээс шаарддаг.

Аудитын ажил нь нэгтгэсэн санхүүгийн тайлан дах дүн болон тодруулгын үндэслэлийг тестийн үндсэн дээр шалгаж батлах ажлыг багтаадаг. Нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь алдаа эсвэл залилангийн улмаас гарч болох материаллаг буруу тайлагналтай байж болох эрсдлийг үнэлэх зэрэг горимуудыг аудитор өөрийн шийдлээр сонгож авна. Тэдгээр эрсдлийн үнэлгээг хийхэд байгууллагын дотоод хяналтын системийн үр нөлөөтэй байдлын талаар дүгнэлт гаргах зорилгоор биш харин тухайн нөхцөл байдалд зохистой аудитын горимуудыг зохиохын тулд санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, үнэн зөв танилцуулахтай холбоотой дотоод хяналтыг аудитор авч үздэг. Түүнчлэн аудитын ажил нь санхүүгийн тайланг бүхэлд нь үнэлэхээс гадна, удирдлагын зүгээс хийсэн тооцоолууд, хэрэглэсэн бүртгэлийн зарчмуудыг шалгах ажлыг өөртөө агуулдаг.

Бидний хийсэн аудитын ажил нь эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайланд хязгаарлалттай дүгнэлт гаргах хангалттай үндэслэл болж чадна гэж үзлээ.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Хязгаарлалтын үндэслэл

Тэмдэглэл 16 Худалдааны ба бусад авлагын дүнд багтсан "Дархан хөвөн" ХК-иас авах 484,982 мянган төгрөгийн авлага, "Силикат" ХК-иас авах 94,803 мянган төгрөгийн авлагууд 3-5 жилийн хугацаанд эргэн төлөгдөөгүй, хөдөлгөөнгүй байсан бөгөөд эргэн төлөгдөх эсэх нь эргэлзээтэй байна. Компани эдгээр авлагуудын эргэн төлөгдөх байдалд шинжилгээ хийж, үнэ цэнийн бууралт байгаа эсэхийг үнэлээгүй бөгөөд аудиторуд бид аудитын нэмэлт горим гүйцэтгэх замаар эдгээр авлагуудыг бодит үнэ цэнээр нь хэмжиж залруулах замаар санхүүгийн тайланг өөрчлөх боломжгүй байсан. Эдгээр авлагын эргэн төлөгдөхгүй байж болох дүнг данснаас хасвал компанийн хуримтлагдсан ашиг энэ хэмжээгээр буурна.

Компанийн ТУЗ нь компанийн үйл ажиллагааны 2011-ээс 2013 онуудын үр дүнгээс хамаарсан нийт 117,770 мянган төгрөгийн мөнгөн урамшуулал, 116,370 мянган төгрөгийн хувьцааны опцион ажилчдад олгох шийдвэр гаргасан. Гэвч эдгээр урамшууллыг зохих тайлант жилүүдийн нягтлан бодох бүртгэлд тусгаж тухайн тайлант жилд нь зардлаар хүлээн зөвшөөрч Ашиг, Алдагдал болон Бусад Дэлгэрэнгүй Орлогын тайланд тусгаагүй. Эдгээр дүнг өмнөх тайлант жилүүдийн үр дүнг бууруулан залруулбал компанийн хуримтлагдсан ашигийн эхний үлдэгдэл 234,139 мянган төгрөгөөр буурах байсан.

Тэмдэглэл 15 Борлуулахад бэлэн хөрөнгө оруулалт-ын дүнд багтсан "Зоос банк" ХК-ийн нийт 206,061 мянган төгрөгийн хувьцаан дах хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтын тооцооллыг гүйцэтгэж Ашиг, Алдагдал болон Бусад Дэлгэрэнгүй Орлогын тайланд тусгаагүй. Энэхүү хөрөнгө оруулалттай холбоотой үнэ цэнийн бууралтын тооцооллыг хийж гүйцэтгэснээр хамгийн багадаа 94,682 мянган төгрөгийн алдагдал хүлээн зөвшөөрч тайлант жилийн цэвэр алдагдал 94,682 мянган төгрөгөөр нэмэгдэж нөлөөлөх байсан.

Аудиторын дүгнэлт

Бидний дүгнэлтээр, хавсаргасан нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь **Хязгаарлалтын үндэслэл** хэсэгт дурдсанаас бусад бүхий л материаллаг зүйлсийн хувьд, "БиДиСек" ХК-ийн 2014 оны 12 сарын 31-ний өдрийн Нэгтгэсэн санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болсон тайлант жилийн Нэгтгэсэн ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлого, Нэгтгэсэн өмчийн өөрчлөлт болон Нэгтгэсэн мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв бөгөөд шударгаар илэрхийлсэн байна.

Асуудлыг онцлох нь

Энэ тайлангийн 44-р хуудас, **тэмдэглэл 31 Болзошгүй үйл явдал ба томоохон хэлцэл** хэсэгийг санхүүгийн тайлан хэрэглэгчид анхааралтай авч үзвэл зохино. Гэхдээ энд дурдсан асуудлын хувьд бид эдгээр санхүүгийн талаар гаргасан дээрх аудиторын дүгнэлтийн хэлбэрийг өөрчлөөгүй болно.

Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 94-р зүйлд заасан хуулийн этгээд болох "БиДиСек" ХК-ийн хувь нийлүүлэгчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй.



Огноо: 2015 . 01 . 27